



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 7а, Утас: 26-21-35,
Факс: (976-11) 32-21-27, E-mail: info@mfa.gov.mn
<http://www.mfa.gov.mn>

2013.06.05 № 09/3123
танай _____-ны № _____-т

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
АСУУДАЛ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Б.ПҮРЭВДОРЖ ТАНАА

“Дипломат болон албан паспорт
эзэмшигчдийг визийн шаардлагаас харилцан
чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар,
Камбожийн Вант Улсын Засгийн газар
хоорондын хэлэлцээр” 2012 оны 9 дүгээр сарын
27-ны өдрөөс хүчин төгөлдөр болсныг үүгээр
мэдэгдэж байна. Холбогдох арга хэмжээ авахыг
хүсье.

Хавсралт: 4 хуудас

ГЭРЭЭ, ЭРХ ЗҮЙН
ГАЗРЫН ЗАХИРАЛ

Б.МАНДАХБИЛЭГ

903918

Монгол улсын Засгийн газрын
хэрэгжүүлэгч агентлаг
ГАДААДЫН ИРГЭН ХАРЬАТЫН
АСУУДАЛ ЭРХЛЭХ ГАЗАР
ТТБ № 2052

Бүртгэсэн № 1181 карт № ..
Огноо 2013.06.05
12 .. цаг .. минутанд

.....-д
шилжүүлэв.
Хуудасны тоо 5

**ДИПЛОМАТ БОЛОН АЛБАН ПАСПОРТ ЭЗЭМШИГЧДИЙГ ВИЗИЙН
ШААРДЛАГААС ХАРИЛЦАН ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
КАМБОЖИЙН ВАНТ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар болон Камбожийн Вант Улсын Засгийн газар (цаашид "Талууд" гэх),

Хоёр улсын хооронд найрамдал, хамтын ажиллагааны харилцааг бэхжүүлэхийг эрмэлзэн,

Хоёр улсын дипломат болон албан паспорт эзэмшигч иргэд хоёр улсын нутаг дэвсгэрт зорчих нөхцлийг хөнгөвчлөх шаардлагыг хүлээн зөвшөөрч,

дараахь зүйлийг харилцан тохиролцов. Үүнд:

1 дүгээр зүйл

Нөгөө Талын нутаг дэвсгэрт албан ёсоор томилогдоогүй, хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигч аль нэг Талын иргэд нь нөгөө Талын нутаг дэвсгэрт нэвтэрсэн өдрөөс эхлэн 30 (гуч) хүртэл хоногийн хугацаатай визгүйгээр орох, дамжин өнгөрөх, зорчих болон гарах эрхтэй.

2 дугаар зүйл

1 дүгээр зүйлд дурдсан хугацааг хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр илгээгч улсын дипломат төлөөлөгчийн газар, эсхүл консулын газраас бичгээр тавьсан хүсэлтийг үндэслэн сунгана.

Талуудын дипломат төлөөлөгчийн газар, эсхүл консулын газар байхгүй тохиолдолд дипломат болон албан паспорт эзэмшигчид хүлээн авагч улсын Гадаад харилцааны яамны консулын газарт хандана.

3 дугаар зүйл

Дипломат болон консулын төлөөлөгчийн газрын гишүүд, эсхүл нөгөө Талын нутаг дэвсгэрт байдаг олон улсын байгууллагын албан ёсны төлөөлөгчид болон тэдгээртэй хамт амьдардаг хүчин төгөлдөр дипломат болон албан паспорттай тэдгээрийн гэр бүлийн гишүүд болох дипломат болон албан паспорт эзэмшигч аль нэг Талын иргэд нөгөө Талын нутаг дэвсгэрт томилолтын хугацаандаа визгүй орох, дамжин өнгөрөх, гарах, оршин сууж болох бөгөөд тэдгээр нь нөгөө талын нутаг дэвсгэрт ирсэн өдрөөс эхлэн 30 (гуч) хоногийн дотор суугаа улсад ажиллах шаардлагыг биелүүлсэн байна.



4 дүгээр зүйл

Энэхүү хэлэлцээрт дурдсан иргэд нөгөө Талын нутаг дэвсгэрт нэвтрэх, дамжин өнгөрөх болон нутаг дэвсгэрээс гарахдаа олон улсын зорчигчдод нээлттэй бүх хил нэвтрэх цэгээр нэвтэрч болно.

5 дугаар зүйл

Аль нэг Талын иргэд нөгөө Талын нутаг дэвсгэрт байх хугацаандаа хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

6 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээр нь тааламжгүй гэж үзсэн нөгөө Талын иргэнийг нэвтрүүлэхээс татгалзах, эсхүл байх хугацаагийн багасгах аль нэг Талын эрхийг хөндөхгүй.

7 дугаар зүйл

1. Талууд энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш гуч (30) хоногоос хэтрэлгүй хугацаанд энэхүү хэлэлцээрт дурдсан өөрсдийн хүчинтэй дипломат болон албан паспортын загварыг дипломат шугамаар харилцан солилцоно.
2. Талууд шинэ дипломат болон албан паспорт ашиглах болсон, эсхүл ашиглаж буй паспортод өөрчлөлт оруулсан тохиолдолд тэдгээрийг ашиглаж эхлэхээс гуч (30) хоногоос хэтрэлгүй хугацаанд тэдгээр паспортын загварыг дэлгэрэнгүй мэдээллийн хамт дипломат шугамаар бие биедээ уламжилна.

8 дугаар зүйл

Аль нэг Тал нийтийн хэв журмыг хамгаалах, эсхүл нийтийн эрүүл мэндийн аюулгүй байдлын шалтгаанаар энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн түдгэлзүүлж болно. Тийнхүү түдгэлзүүлсэн буюу түдгэлзүүлснийг цуцалсан тухайгаа нөгөө Талдаа дипломат шугамаар боломжийн эрт хугацаанд мэдэгдэнэ.

9 дүгээр зүйл

Энэхүү хэлэлцээрийг тайлбарлах, эсхүл хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн аливаа маргааныг Талууд хоорондоо зөвшилцөл болон хэлэлцээний найрсаг замаар шийдвэрлэнэ.

10 дугаар зүйл

1. Энэхүү хэлэлцээр нь гарын үсэг зурснаас хойш гуч (30) хоногийн дараа хүчин төгөлдөр болно.
2. Талууд энэхүү хэлэлцээрт харилцан зөвшилцсөний үндсэн дээр дипломат шугамаар бичгээр харилцан мэдэгдэж нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
3. Энэхүү хэлэлцээр нь аль нэг Тал дипломат шугамаар тус хэлэлцээрийг цуцлах тухайгаа мэдэгдээгүй тохиолдолд хүчин төгөлдөр хэвээр байна. Мэдэгдэлийг хүлээн авсан өдрөөс хойш ер (90) хоногийн дараа хүчингүй болно.

Энэхүү хэлэлцээрийг Пномпень хотноо 2012 оны 8 дугаар сарын 27-ны өдөр монгол, кхмер, англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй. Тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ**



ТҮВДЭНДОРЖИЙН ЖАНАБАЗАР

МОНГОЛ УЛСААС КАМБОЖИЙН ВАНТ
УЛСАД СУУГАА ОНЦ БӨГӨӨД БҮРЭН
ЭРХТ ЭЛЧИН САЙД

**КАМБОЖИЙН ВАНТ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**



ЛОНГ ВИСАЛО

КАМБОЖИЙН ВАНТ УЛСЫН
ГХЯ-НЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



KINGDOM OF CAMBODIA

Ministry of Foreign Affairs
and International Cooperation

No. 2215 MFA-IC/LCI

The Ministry of Foreign Affairs and International Cooperation presents its compliments to the Embassy of Mongolia in Vientiane and, with reference to the Agreement between the Government of the Kingdom of Cambodia and the Government of Mongolia on the Exemption of Visa Requirements for Holders of Diplomatic and Service/Official Passports, signed on 27 August 2012 in Phnom Penh, has the honor to enclose herewith the specimens of Cambodian diplomatic and service passports by the virtue of Article 7 of the said Agreement.

The Ministry has further honor to inform the Embassy that this Agreement will start its effect on 27 September 2012, according to Article 10 of the Agreement.

The Ministry would highly appreciate it if the Embassy could forward the above information and specimens to its highest destination.

The Ministry of Foreign Affairs and International Cooperation avails itself of this opportunity to renew to the Embassy of Mongolia the assurances of its highest consideration.

Phnom Penh, 30 August 2012



Embassy of Mongolia
Vientiane

